



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20... оны ... сарын ... өдөр

Дугаар 7

Улаанбаатар хот

Санхүүгийн
тайланг батлах тухай

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 08-р сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр” ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн “Си Эс Ай аудит” ХХК-иар баталгаажсан санхүүгийн тайланг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан санхүүгийн тайланд дурьдагдсан аудитын байгууллагын санамж, зөвлөгөөг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ОЮУНСҮРЭН





ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 46-р зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 08-р сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гермес центр” ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашиг 1,237,028,612.28 төгрөгийн
 - 1,233,125,115.70 төгрөг (нэг тэрбум хоёр зуун гучин гурван сая нэг зуун хорин таван мянга нэг зуун арван таван төгрөг далан мөнгө) -ийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашигт хуваарилсугай.
 - 3,903,496.58 төгрөг (гурван сая есөн зуун гурван мянган төгрөг дөрвөн зуун ерөн зургаан төгрөг тавин найман мөнгө)-ийг компанийн хуримтлагдсан ашигт үлдээсүгэй.
2. “Гермес центр” ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76.1.12-р заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 08-р сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 15 төгрөг 70 мөнгө (арван таван төгрөг далан мөнгө)-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 09-р сарын 15-ны өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны эхний хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2025 оны 09-р сарын 15-ны өдрөөс 11-р сарын 20-ны өдрийн дотор хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн харилцах данс болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-тай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдэд олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН